



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

Аудитын ерөнхий дүгнэлт: Орлогын нэр төрлөөр авч үзэхэд 21 нэр төрлийн орлогоос 16 нэр төрлийн орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

Аудитын нэр:

**ТӨВ АЙМГИЙН 2014 ОНЫ НЭГДСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**Зуунмод
2015 он**

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар..... .3
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт..... .4
	Аудитын дүн.....
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	БҮЛЭГ -1
Аудитын менежер О.Амаржаргал	Дүгнэлт 1
	Ус, рашаан ашигласны төлбөрийн төлөвлөлтийн үндэслэл муутай байна.5-7
Аудитор Т.Майцэцэг Ц.Саранчимэг О.Сосор	БҮЛЭГ- 2
	Дүгнэлт 1
	Орлогын нэр төрлөөр авч үзэхэд 21 нэр төрлийн орлогоос 16 нэр төрлийн орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.....7-10
2015 оны 05 дугаар сарын 11	БҮЛЭГ- 3
	Дүгнэлт 1
	Төв аймгийн ТЭЗ-ийн нийт зарлагын 38.4 хувийг аймгийн Засаг даргын багц, 34.7 хувийг БСШУСайдын багц, 8.1 хувийг Эрүүл мэндийн сайдын багц эзэлж байна. 11-15
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. http://tuv-audit.mn/	Дүгнэлт.....16
	Зөвлөмж.....17
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 22582 дугаарын факсаар харилцана уу.	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал18
ХАЯГ:	
Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний Аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
БХБЯам	Барилга хот байгуулалтын яам
НХХСайд	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд
ССАЖСайд	Соёл, Спорт, Аялал жуулчлалын сайд
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААН	Аж ахуйн нэгж
УБЦТС	Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ
ХҮТ	Хэрэглэгчидэд үйлчлэх төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ҮХААЯ	Үйлдвэр хөдөө аж ахуйн яам
АТБӨЯХ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОАТ	Орлогын албан татвар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ДЭХ	Дулааны эрчим хүч
СТСХ	Санхүү Төрийн сангийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ӨМӨЗО	Өвөр монголын өөртөө засах орны
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
МУЗГ	Монгол улсын Засгийн газрын

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төв аймгийн Аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт: Төв аймгийн 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт гарган ҮАГ-т хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

- 1.Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл
- 2.Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
- 3.Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

Аудитын хамрах хүрээ: Аудитаар орон нутгийн төсөв, Хүний хөгжил сан, Нийгмийн даатгалын сан, ТЕЗ болон орон нутгийн ТЕЗ-чид, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуй нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудит хийв.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Монгол Улсын үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн хууль
- Хүнийн хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Хүний хөгжил сангийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Төв аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Т.Майцэцэг, О.Сосор, Ц.Саранчимэг нар 2015 оны 05-р сарын 01-нээс 05-р сарын 11-нийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

Бүлэг 1

*Ус, рашаан ашигласны төлбөрийн төлөвлөлтийн
үндэслэл муутай байна.*

1.1 Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсөв Төсвийн тусгай шаардлагуудыг хангаж зорилтот түвшинд хүрч чадсан уу?

1.1 2014 онд төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, орлогыг бодитой төлөвлөх, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, татвар хураалтыг эрчимжүүлэх, төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөр арга хэмжээг жигд хэрэгжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх зарчмыг баримтлан орлогын төлөвлөгөөг ногдуулалт, урьд оны гүйцэтгэл, ХБГүйцэтгэл, УИХ, Сангийн яамнаас өгсөн чиглэлийг үндэслэн аймаг, сумын ИТХурлын хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан байна.

2014 оны төсвийн зарлагыг төлөвлөхдөө дараах зарчмуудыг баримталсан байна.

- төсвийн урсгал зардлын өсөлтийг хязгаарлаж, өмнөх оны түвшинд төлөвлөх,
- тэвчиж болох урсгал зардлыг хэмнэх, үр ашиггүй зардлыг төсөвт тусгахгүй байх замаар төсвийн зарлагын тэлэлтийг хязгаарлах,
- төсвийн байгууллагуудын урсгал зардал, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, орон тоо урсгал зардлыг нэмэгдүүлэх үр дагавар бүхий аливаа шийдвэрийг хэрэгжүүлэхдээ ажлын ачаалалыг нягтруулах, бүтэц чиг үүргийг оновчтой тогтоох замаар өмнөх оны төсвийн түвшинд багтаах гэх мэт.

Төсвийн зарлагын төлөвлөгөөг Засгийн Газрын 2012 оны 30-р тогтоолоор баталсан орон нутгийн төсвийн аргачлалын дагуу тогтмол болон хувьсах зардал, орон нутгийн суурь зардалд хамрагдах халамжийн зардал, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг тооцон төсвийн төлөвлөлтийг хийсэн. Аймаг сумын ОНХСангийн төлөвлөлтийг мөн тогтоолоор баталсан аргачлалын дагуу хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, алслалт, татварын идэвхи санаачилга гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан тооцож хуваарилан батлуулжээ.

2014 онд Төв аймгийн суурь орлого 10272.5 сая төгрөг, суурь зарлага 20521.3 сая төгрөгөөр тооцогдож, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 10248.8 сая төгрөг байна. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг төсөвт байгууллагуудын төсвийг харьяа салбарын яамдуудад хүргүүлэн хянуулж аймгийн ИТХурлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.

1.2 Монгол Улсын 2014 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Төв аймгийн 2014 оны төсвийн орлого, эх үүсвэрийг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас баталсан болон тодотгосон төлөвлөгөөгөөр 69431.8 сая төгрөгөөр баталсан. Үүнд:

- Татварын ба татварын бус орлого 11071.3 сая төгрөг
- Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 10176.3 сая төгрөг
- Орлогын шилжүүлгээр Орон Нутгийн Хөгжлийн санд 9618.2 сая төгрөг
- ТЗШилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 35939.1 сая төгрөг
- ТЗШилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлого 105.5 сая төгрөг
- Төсвийн шилжих үлдэгдэл 2046.9 сая төгрөг
- Аймгийн төсвийн хэмнэлт 474.5 сая төгрөг байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 03-р сарын 27-ны өдрийн 10-р хуралдааны 07 тоот тогтоолоор Төсвийн тухай хуулийн 34.2.1-д “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалт, Монгол улсын 2014 оны төсвийн тодотголыг үндэслэн аймгийн 2014 оны төсөвт дараах тодотголуудыг хийсэн байна.

1. Үл хөдлөх хөрөнгийн татварыг 18.0 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийг 132.9 сая төгрөг, татварын буцаан олголтын санг 255.8 сая төгрөгөөр нэмж тодотгосоноос татварын орлого 106.8 сая төгрөгөөр буурсан байна.
2. Хүү торгуулийн орлого 30.0 сая төгрөг, нэр зааж ангилагдаагүй орлого 100.0 сая төгрөг нэмж татварын бус орлого 130.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
3. Монгол улсын 2014 оны төсвийн тодотголоор аймагт олгох санхүүгийн дэмжлэг 10176.3 сая төгрөг болж оны эхний төлөвлөгөөнөөс 72.5 сая төгрөгөөр буурсан, тусгай зориулалтын шилжүүлэг 35939.1 сая төгрөг болж 1339.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 689.3 сая төгрөгөөр буурсан байна.

Татварын хэлтсээс гаргасан ногдуулалтыг батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад цалингийн ашиг 237.0 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 26.0 сая төгрөгөөр тус тус дутуу тооцож төлөвлөсөн байна. Харин усны төлбөр ногдуулалтаас 84.0 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн ч урьд оны дутуу төлөлтийг тооцоогүйгээс 2014 оны усны төлбөрийн орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 44.1 хувиар буюу 622.6 сая төгрөгөөр давж биелсэн байгаагаас үзэхэд ус, рашаан ашигласны төлбөрийн төлөвлөлт үндэслэл муутай байна.

Төв аймгийн ТЕЗ-ийн төсвийн 2014 онд зарцуулах зарлагыг аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас оны эхэнд нийт 68761.4 сая төгрөгөөр баталсан. Тайлант оны дундуур 19 сумдын ИТХурлаас 670.4 сая төгрөгийг нэмж зарцуулахаар тодотгосон байна. Оны дундуур тодотгол хийсэн сумдын Засаг дарга нар нь Төсвийн тухай хуулийн 34.2.1-д “дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон”, 34.2.2-д “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 66.1.4-д “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ТЕЗ-ын 2014 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дээрх 19 сумын тодотголоор баталсан төлөвлөгөөг орлого, зарлагын төлөвлөгөөнд нэмж тусгуулсан.

2014 оны Төв аймгийн төсвийн зарлагын баталсан төлөвлөгөөг төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцаар харуулвал

д/д	үзүүлэлт	/сая төгрөг/	
		Батлагдсан төлөвлөгөө	эзлэх хувь
1	Аймгийн Засаг дарга	32160.4	46.3
2	БСШУСайд	26409.6	38.0
3	БХБЯам	237.5	0.3
4	НХХСайд	241	0.3
5	Эрүүл мэндийн сайд	6182.6	8.9
6	ССАЖСайд	2973.9	4.3
7	Төсөл сан	1226.8	1.8
	Дүн	69431.8	100

Төв аймгийн ТЕЗ-ийн төсвийн зарлагын төлөвлөгөөг Ерөнхийлөн захирагчийн багцаар авч үзвэл нийт зарлагын 46.3 хувийг аймгийн Засаг даргын багц, 38.0 хувийг БСШУСайдын багц, 8.9 хувийг Эрүүл мэндийн сайдын багц зарцуулсан байгаа нь нийт зарлагын 93.2 хувийг эзэлж байна.

Бүлэг 2

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд 21 нэр төрлийн орлогоос 16 нэр төрлийн орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

2.1 Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээг бүрэн авч чадсан уу?

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 10-р хуралдааны 07 тоот тогтоолоор орлогын төлөвлөгөөг 67112.5 сая төгрөгөөр, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2319.3 сая төгрөгөөр, нийт 69431.8 сая төгрөгөөр тодотгон баталсан. Нэгдсэн төсвийн орлого гүйцэтгэлээр 68451.7 сая төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөнөөс 980.1 сая төгрөгөөр эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна.

Орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөгөөр/

	Төсвийн орлого	2014 оны тодотгосон төлөвлөгөө /сая төгрөг/	Аудитлагдсан гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү дүн	хувь
1.1-2	Татварын ба Татварын бус орлого	11071.3	12819.9	1748.6	115.8
3.1	Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	10176.3	10176.3	0	
3.2	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	9618.2	6889.5	-2728.7	71.6
3.3	Тусгай зориулалтын шилжүүлэг	36044.6	36044.6	0	
3.4	Аймгийн төсвийн шилжих үлдэгдэл	2046.9	2046.9	0	
3.5	Аймгийн төсвийн хэмнэлтийн үлдэгдэл	474.5	474.5	0	
	Нийт дүн	69431.8	68451.7	-980.1	98.6

Хүснэгтээс үзвэл:

- Тайлант онд батлагдсан төлөвлөгөөний дагуу улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 10176.3 сая төгрөгийг бүрэн авсан.
- Орон нутгийн болон аймгийн төвлөрсөн төсвийн орлогоор ХХОАТатварын буцаан олголтонд 524.6 сая төгрөгийг хасч нийт 11071.3 сая төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр нийт 12819.9 сая төгрөгийн орлого төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 1748.6 сая төгрөгөөр илүү буюу 115.8 хувиар давж биелэсэн.
- Орон Нутгийн Хөгжлийн санд 9618.2 сая төгрөгийн санхүүжилт авахаас 6889.5 сая төгрөг санхүүжигдэж, батлагдсан төлөвлөгөөнөөс 2728.7 сая төгрөгийг дутуу санхүүжигдсэн.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 36044.6 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн байна.

Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр авч үзэхэд 21 нэр төрлийн орлогоос 16 нэр төрлийн орлого 101.7-529.2 хувиар биелсэн байна. Орлогын төлөвлөгөөг 106.4 сая төгрөгөөс дээш дүнгээр давуулан биелүүлсэн орлогыг жагсаавал Үүнд:

1. Ус ашигласны төлбөр 662.6 сая төгрөгөөр буюу 144.1 хувиар давж биелэсэн нь Алтан Дорнод, Мондулаан, Олово зэрэг ААН-нэгжүүдийн өмнөх оны дутуу төлөлт 772.5 сая төгрөгийн усны төлбөрийн төлөлт хийгдсэнтэй холбоотой байна.

2. Нэр зааж ангилагдаагүй орлого 395.7 сая төгрөгөөр буюу 167.0 хувиар биелэсэн нь аймгийн ИТХ-ын 2012.07.04-ны 77-р тогтоолын дагуу газрын дуудлага худалдааны анхны үнийн нөхөн төлөлт, Жаргалант суманд ажиллах хүчний төлбөр 278.0 сая төгрөг орсноор орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.
3. Хүү торгуулийн орлого 179.2 сая төгрөгөөр буюу 125.3 хувиар биелэсэн нь Баянчандманьд "Монвольфром" ХХК-д 50.0 сая, Лүн, Борнуур, Сэргэлэн сумдад тус бүр 10.0 гаран сая төгрөгийн татварын хяналт шалгалтын актын төлбөр төлөгдсөн байна.
4. Байгалийн ургамал ашигласны төлбөр 155.8 сая төгрөгөөр буюу 529.2 хувиар биелэсэн нь Мөнгөнморьт суманд тайлант онд самар, жимс элбэг ургаж ихэнх орлогыг бүрдүүлсэн байна.
5. Газрын төлбөр 139.4 сая төгрөгөөр буюу 113.5 хувиар биелэсэн нь газрын дуудлага худалдааны орлого 132.1 сая төгрөг, урьд оны дутуу төлөлт 13.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс илүү орсон нь нөлөөлсөн байна
6. Агнуурын нөөц ашигласны төлбөр 115.7 сая төгрөгөөр буюу 478.8 хувиар биелэсэн нь Лүн, Өндөрширээт, Баян-Өнжүүл зэрэг сумдад буга, угалз зэрэг амьтдыг агнах тусгай зөвшөөрөл олгосон байна.
7. Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 106.4 сая төгрөгөөр буюу 200.5 хувиар биелэсэн нь Баян, Баянцагаан, Бүрэн, Лүн, Өндөрширээт, Сэргэлэн, Угтаал, Эрдэнэ сумдад 90 жилийн ой тохиолдож баяр наадам, уралдаан тэмцээн зохион байгуулагдаж шагналаас авах татварын орлого өссөн байна.

Төв аймгийн Зуунмод сум нь хог хаягдлын хураамжийг УБЦТС ХК-ний Зуунмод ХҮТ-тэй гэрээ байгуулан айл өрхийн цахилгааны үнэнд оруулан татварын орлогыг төвлөрүүлсэн байна. Гэрээний дагуу 2014 онд хог хаягдлын хураамжийн төсөвт төвлөрсөн орлогын 23 хувь буюу 15.5 сая төгрөгийн мөнгөн урамшуулалыг Зуунмод ХҮТөвд төлсөн байгааг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичлээ. Энэ нь татварын албаны татвар хураах үүргийг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж Төсвийн тухай хуулийн 23.8-д “сум дүүргийн татварын орлогод хог хаягдлын үйлчилгээний хураамж хамаарна”, Монгол улсын Татварын ерөнхий хуулийн 22.1.3-д “үндэсний татварын алба нь улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн хүчин зүйлс бодитой байна уу?

Төв аймгийн татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 115.8 хувиар биелсэн боловч сумын орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын төлөвлөгөөг Алтанбулаг, Баянжаргалан, Баянцагаан, Баянцогт, Дэлгэрхаан, Угтаал, Эрдэнэ зэрэг сумд 9.8-37.3 хувиар тасалж, аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг Баянжаргалан, Сүмбэр, Жаргалант зэрэг сумд нь 20.0-69.4 хувиар тасалсан байна.

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзвэл 5 нэр төрлийн орлого 4.8-47.3 хувиар тасарсан байна. Үүнд:

1. ХХОАТатварын үйл ажиллагааны орлого 77.6 сая төгрөгөөр буюу 21.6 хувиар тасрахад Засгийн газрын 2013.11.30-ны өдрийн 394 тоот тогтоолын дагуу малчдад олгох ноосны урамшуулалыг Сангийн яам болон ҮХААЯамнаас ирүүлээгүй нь нөлөөлсөн байна.
2. АТБӨЯХэрэгслийн албан татвар 19.2 сая төгрөгөөр буюу 7.5 хувиар тасарсан нь гадны дугаартай автомашины татварыг харьяалалын дагуу бусад аймаг, дүүргүүдийн татварын орлогын дансанд буцаан шилжүүлсэнтэй нь холбоотой байна.
3. Улсын тэмдэгтийн хураамж 16.0 сая төгрөгөөр буюу 4.8 хувиар тасрахад Баян, Баянжаргалан, Борнуур, Цээл, Эрдэнэ, Зуунмод сумд улсын тэмдэгтийн хураамжаар 65.9 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээс 22.1 сая төгрөгийн татварын орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 43.8 сая төгрөгөөр буюу 33.3-79.8 хувиар тасарсан нь нөлөөлсөн байна.

4. Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрөлийн хураамж 10.5 сая төгрөг буюу 47.3 хувиар тасарсан нь Эрдэнэ сумын "Алтайн түрүү" ХХК боржин чулууны үйлдвэрийн үйл ажиллагаа стандартад нийцээгүй учир Мэргэжлийн хяналтаас газраас үйл ажиллагаа явуулахыг хориглосон шийдвэр гарч үйл ажиллагаа хэвийн явагдаагүйгээс орлого тасархад нөлөөлсөн байна.
5. Төсөвт байгууллагын өөрийн орлого 66.5 сая төгрөг буюу 36.3 хувиар тасарсан байна. Үүнд аймгийн ЗДТГ-ын туслах аж ахуй нь өөрийн орлогын эх үүсвэрээр санхүүждэг байсныг түрээсийн гэрээгээр гүйцэтгэхээр үйл ажиллагааны чиглэлийг өөрчилсөнтэй холбогдуулан 2014 онд 94.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

		/сая.төгрөг/			
№	Татварын орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орлогыг тодорхойлох боломжгүй иргэдийн орлого	38.3	44.9	6.6	117.1
2	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	5716.2	5815.4	99.2	101.7
3	Мал бүхий иргэний орлого	0.0	0.2	0.2	0.0
4	Үйл ажиллагааны ОАТ	359.9	282.3	-77.6	78.4
5	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар	105.9	212.3	106.4	200.5
6	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	217.0	231.3	14.3	106.6
7	АТБӨЯХэрэгслийн татвар	257.2	238.0	-19.2	92.5
8	Бууны албан татвар	3.6	4.5	0.9	124.4
9	Улсын тэмдэгтийн хураамж	333.2	317.2	-16.0	95.2
10	Газрын төлбөр	1028.7	1168.1	139.4	113.5
11	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (Алтны нөөц)	22.3	11.7	-10.5	52.7
12	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	163.2	168.2	5.0	103.1
13	Ус ашигласны төлбөр	1413.3	2035.9	622.6	144.1
14	Агнуурын нөөц ашигласны	30.5	146.2	115.7	478.8
15	Ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр	176.6	196.3	19.7	111.2
16	Байгалийн ургамал ашигласны төлбөр	36.3	192.1	155.8	529.2
17	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	54.4	116.7	62.3	214.5
18	Түрээсийн төлбөр	15.4	23.4	7.9	151.4
19	Хүү торгууль	707.8	887.0	179.2	125.3
20	Нэр зааж ангилагдаагүй орлого	591.0	986.8	395.8	167.0
21	Хог хаягдлын хураамж	141.9	149.4	7.5	105.3
22	ТБӨОрлого	183.2	116.7	-66.5	63.7
	ДҮН	11596.0	13344.6	1748.6	115.1
23	Буцаан олголт	524.7	524.7	0.0	100.0
	Татварын буцаан олголт хассан дүн	11071.4	12819.9	1748.6	115.8

2.3 Орлогын бүх гүйлгээ тухайн төсөв захирагчийн төрийн сангаар дамжин хийгдэж чадаж байна уу?

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд төрийн сангийн чиг үүргийг төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих, төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх, төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх, төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох, төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих, төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх, төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах, төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох талаар хуульчилан заасан байна. Аймаг, сумдын Төрийн сан нь төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу төсвийн байгууллагын бүртгэлийн дансыг батлагдсан төсвийн хуваарийн дагуу орлого, зарлагын гүйлгээг хянаж, төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд болон сумдын эргэлтийн эмийн сангуудын орлого арилжааны банкаар хийгдэж бусад бүх орлогын гүйлгээ төсөв захирагчийн төрийн сангаар дамжин хийгдэж байна.

2.4 Төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудад орлого нэмэгдүүлэх боломж байсан уу?

Төв аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн өмчит Зуунмод махны үйлдвэр, Төв Чандмань ДЭХГазрын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Аймгийн ИТХурлаар аймгийн төсвийн нийт орлогыг батлахдаа орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын борлуулалтын орлогын төлөвлөгөөг оруулаагүй баталсан. Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын батлагдсан орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэж тайлагнаагүй зөвхөн зардлын гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Төв Чандмань ДЭХ ОНӨҮГазар нь 2014 онд үндсэн үйл ажиллагааны болон үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 4205.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 5084.9 сая төгрөгийн орлого олж батлагдсан төлөвлөгөөг 879.2 сая төгрөг буюу 120.9 хувиар давуулан биелүүлсэн байна. Үйл ажиллагааны орлого өсөхөд дулаан борлуулах нэгж талбай үнэ өссөн, шинээр орон сууц баригдсантай холбоотой талбай нэмэгдсэн, Бүрэн суманд нэгдсэн халаалт шинээр тавигдсан, тендерээр барилга сантехникийн угсралтын ажил хийгдсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Төв Чандмань ДЭХ ОНӨҮГазар нь 2013 онд 3999.4 сая төгрөг, 2014 онд 5084.9 сая төгрөгийн орлогын бүрдүүлсэн байна. Орлогыг өмнөх онтой харьцуулахад 1085.5 сая төгрөгөөр буюу 127.1 хувиар өссөн байна.

Тус газар нь аймаг болон улсын хөрөнгө оруулалттай ажлын тендерт оролцож 2013 онд 493.3 сая төгрөгийн, 2014 онд 528.5 сая төгрөгийн үндсэн бус үйл ажиллагааны орлого оруулсан байна. Иймээс үндсэн үйл ажиллагааны орлогоос гадна тусгай зөвшөөрлийн дагуу барилга сантехникийн угсралтын ажлыг тендерээр гүйцэтгэвэл орлого нэмэгдэх боломж байна.

Зуунмод мах боловсруулах үйлдвэр ОНӨҮГазар нь тайлант онд нийт 119.9 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулсан бүтээгдхүүний өртөгт 99.2 сая төгрөг, зардалд 61.3 сая төгрөг нийт 160.5 сая төгрөгийн зардал гаргаж 40.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Өмнөх оны борлуулалт 90.5 сая төгрөг байсантай харьцуулахад 29.4 сая төгрөгөөр өссөн байна. Тус байгууллага нь аймаг хөгжүүлэх сангаас авсан 65.0 сая төгрөгийн зээлийг төлөх хугацаа дууссан байхад нэг ч төгрөг барагдуулаагүй, нэмж 50.0 сая төгрөгийн зээл авсан боловч үйл ажиллагаанд нь ямар ч ахиц гараагүй байна. Цаашид ОНӨҮГ-ын менежментийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлвэл орлого нэмэгдэх боломжтой байна.

Бүлэг 3

Төв аймгийн ТЭЗ-ийн нийт зарлагын 38.4 хувийг аймгийн Засаг даргын багц, 34.7 хувийг БСШУСайдын багц, 8.1 хувийг Эрүүл мэндийн сайдын багц эзэлж байна.

3.1 Төсвийн зарлагын төлөвлөгөөний гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан бодитой, үнэн зөв байна уу?

3.1.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Төв аймгийн ТЭЗ-ийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайлангаар төсвийн зарлагын батлагдсан төлөвлөгөө 69437.9 сая төгрөг, гүйцэтгэл 75701.8 сая төгрөг байна.

Сангийн яаманд Төв аймгийн ТЭЗ-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар аудитлагдсан төсвийн зарлагын төлөвлөгөөг 68761.4 сая төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 75760.1 сая төгрөгөөр өөрчлөн нэгтгүүлсэн байна.

Сангийн яам нь төсвийн зарлагын төлөвлөгөөнөөс сумдын ИТХурлаар тодотгон баталсан 670.4 сая төгрөгийг шийдвэргүй гэж хасч, төсвийн зарлагын гүйцэтгэлийг төрийн сангийн данснаас нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан 36.3 сая төгрөгийн санхүүжилт болон орон нутгийн орлогын дансанд тусгай сангийн данснаас төвлөрүүлсэн 22.0 сая төгрөг, нийт 58.3 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмж тайлагнасан байна.

2014 оны төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайлан ТЭЗ-н багцаар харуулбал /сая төгрөгөөр/

д/д	үзүүлэлт	Нэгтгэсэн тайлангаар			Зөрүү	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	эзлэх хувь	тоо	хувь
1	Аймгийн Засаг дарга	32160.4	29076	38.41	3071.4	90.4
2	БСШУСайд	26409.6	26301.6	34.74	108	99.6
3	БХБЯам	237.5	237.5	0.31	0	100
4	НХХСайд	241	234.9	0.31	6.1	97.5
5	Эрүүл мэндийн сайд	6182.6	6137.9	8.11	44.7	99.3
6	ССАЖСайд	2973.9	2913	3.85	60.9	98
7	Төсөл сан	1226.8	4500.4	5.94	-3254.5	361.2
8	ТӨҮГазар		6300.5	8.32	-6300.5	
	Дүн	69431.8	75701.8	100	-6263.9	109

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар батлагдсан төлөвлөгөө нийт дүнгээр 6263.9 сая төгрөг хэтэрсэн нь Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын зардалыг нэгтгээгүйгээс шалтгаалсан байна.

Төв аймгийн ТЭЗ-ийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг сайдын багцаар авч үзвэл нийт зарлагын 38.4 хувийг аймгийн Засаг даргын багц, 34.7 хувийг БСШУСайдын багц, 8.1 хувийг Эрүүл мэндийн сайдын багц зарцуулсан байгаа нь нийт зарлагын 81.2 хувийг эзэлж байна.

Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийг сайдын багцаар авч үзвэл:

- Батлагдсан төлөвлөгөөг аймгийн Засаг даргын багц 3071.4 сая төгрөгөөр, БСШУСайдын багц 108.0 сая төгрөгөөр, НХХСайдын багц 6.1 сая төгрөгөөр, Эрүүл

мэндийн багц 44.7 сая төгрөгөөр, ССАЖСайдын багц 60.9 сая төгрөгөөр нийт 3291.1 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

- Төсөл сангуудын зарлагын гүйцэтгэлээр батлагдсан төлөвлөгөөг 3254.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Байгал хамгаалах сангаас бусад төсөл сан батлагдсан төлөвлөгөөгүй байгаатай холбоотой байна.
- Төрийн өмчит үйлдвэрийн газруудын батлагдсан төлөвлөгөөг нэгтгэж тайлагнаагүй гүйцэтгэлээр 6300.5 сая төгрөг зарцуулсан байна.

2014 оны төсвийн хэтрэлт хэмнэлтийг зардлын зүйл ангиар авч үзвэл:

- Цалин, шимтгэл, тогтмол зардал, хоол, эм зэрэг урсгал зардлуудыг батлагдсан төлөвлөгөөнөөс 0.1-471.6 сая төгрөгөөр, нийгэм халамж үйлчилгээний зардал нь 1648.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалын зардал 1.8 сая төгрөгөөр, дотоод хөрөнгө оруулалтын зардал 28.3 сая төгрөгөөр, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардал 1277.1 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.
- Бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, эд хогшил худалдан авах, нормын хувцас, урсгал засвар, байрны түрээс, орон нутгийн хуваарлагдаагүй, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, байгал хамгаалах зардал, төлбөр хураамж 0.4-266.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.
- Бусад зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 2934.3 сая төгрөгөөр хэтэрсэн нь батлагдсан төлөвлөгөөгүй сум хөгжүүлэх сан, эм эргэлтийн сан, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан, мал хамгаалах сан гэх мэт сангуудыг нэгтгэсэн байна.

ТЕЗ болон СТСХэлтэс нь төсвийн гүйцэтгэлийн тайлан, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хийж ирүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54.5-т “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.4-т “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/”, 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн талаар тодруулга тайлан ирүүлээгүй тул зардлын хэтрэлт хэмнэлтэнд дүгнэлт өгөх боломжгүй байлаа.

ТШЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн төсвийн зарцуулалттай холбоотой зөрчлөөс дурьдвал:

1 Цалингийн сангийн зарцуулалтын талаар:

- Батлагдсан орон тооноос аймгийн ЗДТГазар нь Засаг даргын 1 орлогч, ГХБХБГазар 3 ажилтан, Хот тохижуулах газар 6 ажилтан Батсүмбэр сумын Ойн анги нь 1 ажилтан, Мөнгөнморьт сумын ойн анги нь 2 ажилтан тус тус илүү, Алтанбулаг, Сүмбэр, Баянхангай, Мөнгөнморьт, Угтаал, Эрдэнэ зэрэг сумдын ИТХУрал нь хурлын ажилтан ажиллуулсан.
- Баян сум нь сумын Засаг даргын зөвлөх, Хөдөлмөр, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Цээл сум нь Барилгын ажил хянах хяналтын инженер гэрээгээр ажиллуулсан, Баянжаргалан, Баянцагаан, Өндөрширээт, Аргалант, Лүн, Баянхангай, Баянцогт зэрэг сумд нь хөдөлмөрийн мэргэжилтэнг ажиллуулж 20-40 хувийн нэмэгдэл олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-д батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох, Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 147-р тогтоол зэргийг хэрэгжүүлээгүй, Засгийн газрын 2011.01.25-ний өдрийн 20-р тогтоолын дагуу Төв аймгийн Засаг даргын 2012.05.23-ний өдрийн а/324 тоот захирамжаар баталсан сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог хэтрүүлэн ажилласан байна.
- Аймгийн ЗДТГазар болон Баян, Угтаал, Эрдэнэ, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Цээл зэрэг сумд нь цалингийн сангаас автомашины сэлбэг, эмэгтэйчүүдийн хүлээн

авалт, удирдлагын зөвлөлийн хоолны үнэ, тэтгэмж, шагнал зэргийг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41.2.2-д батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг зөрчсөн.

- Алтанбулаг, Батсүмбэр, Баянжаргалан, Дэлгэрхаан, Заамар, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Эрдэнэ, Баян, Баянцогт, Баянчандмань, Сэргэлэн сумдууд цалингийн зардлаас торгууль суутгасныг төсөвт шилжүүлээгүй, нэмэгдэл хөлсийг олгохдоо тогтоосон журмаас хэтрүүлэн олгосон, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, шагнал тэтгэмжийг цалингаас гаргаж Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн зарцуулалтын эрхийн журам”-ыг тус тус зөрчиж нийт 14.5 сая төгрөгний зөрчил гаргасан.

Зориулалт бусаар зарцуулсан талаар:

- Батсүмбэр сумын Иргэдийн хурлын төлөөлөгч нар нь ӨМӨЗОрны шилийн гол аймагт туршлага судлах нэрээр аялан 1.9 сая төгрөгийг Баянжаргалан сум нь шинэ жилийн сугалаа, ардчилсан хувьсгал ялсны 25 жилийн ойд зориулсан үйл ажиллагаанд 1.2 сая төгрөг олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан. Энэ нь Засгийн газрын 2014 оны төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай 147-р тогтоол, сангийн сайдын 122-р тушаалын заалтыг зөрчсөн байна.
- Батсүмбэр, Жаргалант сумдад багийн цэцэрлэг шинээр нэмж байгуулан орон тоо бүтцийг нэмэгдүүлээгүй өр үүсгэн жилийн эцэст хоолны хэмнэлтээс барагдуулсан байна.

3.1.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар оны эхэнд 69.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлант онд 3830.9 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 3899.7 сая төгрөгийн зарлагыг нэгтгэж оны эцэст 0.22 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нэмэлт санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй 309.2 сая төгрөгийн үлдэгдлийг аймаг, сумдын орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар хийгдсэн гүйлгээний талаар тодруулга тайлан ирүүлээгүй.

Төв аймгийн ЗДТГазарт нэмэлт санхүүжилтийн дансаар Засаг даргын захирамжаар зарцуулсан зардлуудын талаар:

- Аймгийн ЗДТГазрын урсгал зардлын дансанд нэмэлтээр 391.7 сая төгрөг
- Саммитын үйл ажиллагаанд 140.0 сая төгрөг
- Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 45.5 сая төгрөг
- Нэмэлт санхүүжилтийн дансаар 2-р Богд Жавзундамба хутагтын мэлмий гийсэний 290-н жилийн ойг тэмдэглэхэд 22.1 сая төгрөг
- Хүний эрхийн тулгамдсан асуудал 14 хоногийн аян зохион байгуулахад 2.4 сая төгрөг
- Ардчилсан хувьсгалын 25-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд 20.0 сая төгрөг,
- аймаг, орон нутаг сурталчилах, туршлага солилцоход 15.7 сая төгрөг,
- Алтан намар үйл ажиллагаанд 20.0 сая төгрөг,
- Улсын гарамгай мэргэний дэмжлэгт 5.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Дээрх нэмэлт санхүүжилтийн зарцуулалт Монгол улсын Засгийн газрын 2014 оны 5-р сарын 10-ны өдрийн Төсвийн хэмнэлтийн горимд шилүүлэх зарим арга хэмжээний тухай 147 тоот тогтоол, Сангийн сайдын 2014 оны 122-р тушаалын 4-т “Төсвийн хөрөнгөөр өөрийн байгууллага, хамт олныг сурталчлах, телевизийн шоу, уралдаан тэмцээн, зохион байгуулах баяр ёслол, тэмдэглэлт өдрөөр мэндчилгээ илгээх, бэлэг дурсгал илгээх, ивээн тэтгэх үйл ажиллагаа явуулахгүй байх гэсэн заалтуудыг зөрчиж байна.

3.1.3 Тусгай шилжүүлгийн зарцуулалт

Төв аймгийн ТЭЗ-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ТЗШилжүүлгийн байгууллагууд нь батлагдсан төлөвлөгөө 36044.6 сая төгрөг, гүйцэтгэлээр 35824.9 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 219.7 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна. Хүснэгтээр сая төгрөгөөр харуулав.

д/д	үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Нэгтгэсэн тайлангаар			Зөрүү	
			төлөвлөгөө	гүйцэтгэл	эзлэх хувь	тоо	хувь
1	БСШУСайд	26409.6	26409.6	26301.6	34.74	108	99.6
2	БХБЯам	237.5	237.5	237.5	0.31	0	100.0
3	НХХСайд	241	241.0	234.9	0.31	6.1	97.5
4	Эрүүл мэндийн сайд	6182.6	6182.6	6137.9	8.11	44.7	99.3
5	ССАЖСайд	2973.9	2973.9	2913.0	3.85	60.9	98.0
	Дүн	36044.6	36044.6	35824.9	100	219.7	99.4

3.1.4 ОНӨҮГ-ийн төсвийн зарцуулалт

Төв Чандмань ДЭХ ОНӨҮГазрын ТУЗ-ийн 2014 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн дугаар 03 тоот тогтоолоор үндсэн үйл ажиллагааны зардлыг 4422.8 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг 7.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна. 2014 онд гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны зардал 4329.1 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны зардал 661.0 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулбал үндсэн үйл ажиллагааны зардал 93.6 сая төгрөгөөр буурч, үндсэн бус үйл ажиллагааны зардал 653.8 сая төгрөгөөр өссөн байна.

Зардлын хувьд үндсэн үйл ажиллагааны зардал буурсан нь цалин шимтгэл 70.6 сая төгрөг, шатах тослох материал 9.4 сая төгрөг, хөдөлмөр хамгаалалын зардал 9.8 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна. Үйл ажиллагааны зардал 653.8 сая төгрөгөөр өссөн нь тусгай зөвшөөрөлтэй хийсэн ажлын гүйцэтгэлтэй холбоотой өссөн ба үүнийг ТУЗ-өөр оруулан зарцуулах эрхийг баталгаажуулаагүй захиран зарцуулсан байна.

Зуунмод мах боловсруулах үйлдвэр ОНӨҮГазар нь 2014 онд нийт 119.9 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулсан бүтээгдхүүний өртөгт 99.2 сая төгрөг, зардалд 61.3 сая төгрөг нийт 160.5 сая төгрөгийн зардал гаргаж 40.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3.2 Дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалт, эргэн төлөлт үр дүнтэй байна уу?

Азийн хөгжлийн банкнаас дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага оны эхэнд 380.7 сая төгрөг байснаас үндсэн зээлнээс 34.3 сая төгрөг, хүүнд 10.8 сая төгрөг, нийт 45.1 сая төгрөгийг аймгийн төсвийн зарлагаар батлуулж, оны эцэст 346.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.3 Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Төв аймагт 2014 онд “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль”-аар 7 сайдын багцаас нийт 9100.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 хөрөнгө оруулалт, их засварын ажилд 7450.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдан, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжиж хийгдсэн ба гүйцэтгэлээр 6704.4 сая төгрөг буюу 746.0 сая төгрөг дутуу байна. Үүнд: Лүн сумын “Сумын төвийн шинэчлэл” төслийн 642.0 сая төгрөг, Цээл сумын ЗДТГ, иргэний танхимын үлдэгдэл санхүүжилт 11.0 сая төгрөг, тендерийн хэмнэлт 93.0 сая төгрөг байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд гүйцэтгэлийн аудит хийгдсэн аудитын тайланд дэлгэрэнгүйгээр тайлагнасан болно.

3.3 ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрсэн үр дүн зорилтот түвшинг хангасан уу?

ТЕЗахирагч нь хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрсэн үр дүн зорилтот түвшинг ирүүлээгүй тул тайлан бичих боломжгүй.

3.4 Шилэн дансны тухай хууль бодитой хэрэгжиж байна уу?

2015 оны 1-р улиралын байдлаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 92 байгууллага, төсвийн шууд захирагчийн 159 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн 6 байгууллагын хаяг нээгдэж мэдээлэл тавигдсан байна. Үүнийг хянахад батлагдсан төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлээ 43 байгууллага бүрэн оруулсан, 5.0 сая-аас дээш гүйлгээг 14 байгууллага оруулсан, нууцын зэрэглэлтэй 3 байгууллага мэдээлэл оруулаагүй, 42 байгууллага мэдээлэл оруулаагүй, 158 байгууллага зөвхөн батлагдсан төсвөө оруулсан байна. Бүрэн мэдээллээ оруулсан байгууллага байхгүй байна. Аймаг, сумдын ЗДТГ-ууд орон нутгийн хөгжлийн сангийн болон тендерийн мэдээлэл, төсвийн орлогын мэдээлэл, шийдвэрийн жагсаалтаа оруулаагүй зөрчил байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төвлөрүүлэн захирагчийн тусдаа мэдээлэл оруулаагүй байна.

Байгууллагууд батлагдсан төсөв, сарын мэдээ, улирлын гүйцэтгэлээ мэдээллийн самбартаа бүгд байршуулсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Орлогын нэр төрлөөр авч үзэхэд 21 нэр төрлийн орлогоос 16 нэр төрлийн орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.
2. Усны төлбөр ногдуулалтаас 84.0 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн ч урьд оны дутуу төлөлтийг тооцоогүйгээс 2014 оны усны төлбөрийн орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 44.1 хувиар буюу 622.6 сая төгрөгөөр давж биелэсэн байгаагаас үзэхэд ус, рашаан ашигласны төлбөрийн төлөвлөлт үндэслэл муутай байна.
3. Зуунмод сум нь Татварын албаны татвар хураах үүргийг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж Төсвийн тухай хуулийн 23.8-д “сум дүүргийн татварын орлогод хог хаягдлын үйлчилгээний хураамж хамаарна”, Монгол улсын Татварын ерөнхий хуулийн 22.1.3-д “үндэсний татварын алба нь улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна.
4. ТЕЗ болон СТСХэлтэс нь төсвийн гүйцэтгэлийн тайлан, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хийж ирүүлээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Баярбат, Санхүү Төрийн Сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт нарт зөвлөх нь:

- Орон нутгийн орлого эх үүсвэрийг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг хянаж үнэн зөв мэдээлэх
- Татварын ерөнхий хуулийн 22.1.3-д “үндэсний татварын алба нь улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх үүрэгтэй” гэж заасныг мөрдөж, аж ахуйн нэгжээр татварын орлогыг төвлөрүүлж буй зөрчлийг таслан зогсоох
- Төсвийн зарцуулалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах.
- Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлан, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хийж ирүүлж байх.

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал


**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
41100, Уулзна, Төв аймаг
Утас: 70273025, Факс: 70272037
2015.05.01 /м. /01/074
Төвлөх _____ -ийн № _____ -т

**ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийсэн Төв аймгийн 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.


ЗАСАГ ДАРГА  Д.БАЯРБАТ

01 0187
My doc, A5 locot



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/05

Зуунмод

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 12, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 тоот тушаалын 11 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын нийтлэг эрх, үүргийн дүрэм"-ийн 2.2.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.3.5 дахь заалт, Аймгийн Аудитын газрын удирдлагын зөвлөлийн хуралдааны шийдвэр зэргийг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Төв аймгийн 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Ахлах аудитор Т.Майцэцэг, Ц.Саранчимэг, аудитор О.Сосор нарт даалгасугай.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч ажиллан, хариуг 2015 оны 12 дугаар сарын 25-ны дотор Төв аймгийн Аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг Аймгийн Засаг дарга Б.Баярбат, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт нарт зөвлөсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЖАРГАЛСАЙХАН